

Дебит карт эзэмших гэрээ

20... оны-р сарын өдөр

№....

Улаанбаатар хот

Энэхүү Дебит карт эзэмших гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай, 11 хаягт байрлах Улаанбаатар хотын банк (цаашид “Банк” гэх), нөгөө талаас тоот хаягт байрлах овогтой РД: (цаашид “Карт эзэмшигч” гэх, хамтад нь “Талууд” гэх) нар доорх нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Гэрээний зорилго нь Банк аливаа этгээдийн дотоодод болон олон улсад хэрэглэгдэх төлбөрийн карт эзэмших тухай хүсэлтийг хүлээн авч, карт олгох, карт эзэмшигч нь өөрийн картаар төлбөр тооцоо хийх, үүнтэй холбогдох үйлчилгээг үзүүлэх, үйлчилгээний шимтгэл, хураамжыг банкинд төлөх болон холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гэрээнд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.2.1. **“Төлбөрийн карт”** (цаашид “карт” гэх) гэж “төлбөрийн карт” гэж олон улсад зөвшөөрөгдсөн картын байгууллагын стандарт болон Монголбанкны шаардлагыг нэгэн зэрэг, эсхүл аль нэгийг нь хангасан карт эзэмшигч (цаашид “КЭ” гэх)-д төлбөр хийх боломж олгодог төлбөрийн хэрэгслийг;
 - 1.2.2. **“Картын ПИН код”** гэж төлбөрийн КЭ-ийг картын жинхэнэ эзэмшигч гэдгийг нотлох 4-6 оронтой нууц кодыг;
 - 1.2.3. **“CVV код”** гэж картын бэлдэцийн ар хэсэгт хэвлэгдсэн интернэт худалдан авалт хийхэд ашигладаг 3 оронтой тоог;
 - 1.2.4. **“Интернет ПИН код”** гэж КЭ өөрийн картаа ашиглан интернет худалдан авалт хийхэд тухайн КЭ гэдгийг нотлох 4 оронтой нууц дугаарыг;
 - 1.2.5. **“Үйлчилгээний байгууллага”** (цаашид “ҮБ” гэх) гэж бараа, үйлчилгээнийхээ төлбөрийг төлбөрийн картаар хүлээн авч үйлчлэх талаар Виза интернэшнл болон бусад төлбөрийн картаар үйлчлэгч байгууллагын гишүүн аль нэгэн банк, санхүүгийн байгууллагатай “Хамтран ажиллах гэрээ” байгуулсан хуулийн этгээд, иргэнийг;
 - 1.2.6. **“ПОС төхөөрөмж”** (цаашид “ПОС” гэх) гэж карт хүлээн авагчийн системд холбогдсон, төлбөр хийх зориулалтаар ҮБ-д байршуулсан, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
 - 1.2.7. **“МПОС төхөөрөмж”** гэж ухаалаг гар утасны тусламжтайгаар, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
 - 1.2.8. **“ПОБ төхөөрөмж”** гэж карт хүлээн авагч өөрийн салбар, нэгжид байршуулж, системдээ холбосон, картаар идэвхжиж, гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
 - 1.2.9. **“Автомат теллер машин”** (цаашид “АТМ” гэх) гэж карт хүлээн авагчийн системд холбогдсон, картаар идэвхжиж гүйлгээ хийдэг цахим мэдээ үүсгэгчийг;
 - 1.2.10. **“Хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл”** (цаашид “ХШЕН” гэх) гэж Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээнд мөрдөгдөх хүү, шимтгэл, хураамжийн хувь хэмжээг тогтоосон, банкны www.ubcbank.mn цахим хуудсанд нийтэлсэн үйлчлүүлэгчиддээ мэдэгдсэн баримт бичгийг;
 - 1.2.11. **“Картын жилийн хураамж”** гэж КЭ нь жилд нэг удаа төлөх карт ашигласны төлбөр буюу ХШЕН-д заасан дүнг;
 - 1.2.12. **“Картын дансны доод үлдэгдэл”** гэж ХШЕН-д заасан тухайн Картын дансанд заавал байлгах үлдэгдлийг;
 - 1.2.13. **“Бэлэн мөнгөний шимтгэл”** гэж Банк болон бусад гадаад, дотоодын арилжааны банк, санхүүгийн байгууллагын ПОБ болон АТМ-ээс бэлэн мөнгө авсан дүнд ХШЕН-д заасны дагуу тооцох шимтгэлийг;
 - 1.2.14. **“Шилжүүлгийн гүйлгээний шимтгэл”** гэж Картын данснаас бэлэн бусаар шилжүүлсэн гүйлгээний дүнд ХШЕН-д заасны дагуу тооцох шимтгэлийг;
 - 1.2.15. **“Картын өдрийн зарцуулалтын лимит”** гэж ХШЕН-д тогтоосон Картаар хийгдэх гүйлгээний өдрийн зарцуулалтын дүн, тооны хязгаарыг;
 - 1.2.16. **“Цахим банк үйлчилгээ”** (цаашид “Цахим банк” гэх) гэж харилцагч мобайл, интернэт сувгаар дамжуулан авч буй банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх үйлчилгээг;
 - 1.2.17. **“Картын нэмэлт үйлчилгээний шимтгэл”** гэж Карт дахин захиалах, дэд карт захиалах, Картын ПИН код солих, картын Интернет ПИН кодыг идэвхжүүлэх, картын үлдэгдэл шалгах болон бусад үйлчилгээнд ХШЕН-д заасны дагуу тооцох шимтгэлийг;
 - 1.2.18. **“Карт ашиглагдах хэлбэр”** гэж Contactless буюу зайнаас картыг уншуулж ашиглах, EMV chip технологи буюу ЧИП-ээр картыг уншуулж ашиглах, Magnetic Stripe буюу соронзон туузаар картыг уншуулж ашиглах, Карт дээрх мэдээлэл ашиглан интернэт үйлчилгээний байгууллагаар картыг уншуулж ашиглахыг ойлгоно.
- 1.3. Энэхүү Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд мөрдөгдөж байгаа ХШЕН болон түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд болон Карт ашиглах заавар нь Гэрээний салшгүй хэсэг байна;

Хоёр. Карт олгох, картан данс

- 2.1. Банк нь Карт эзэмших хүсэлт гаргагч этгээдээс ирүүлсэн дор дурдсан баримт бичгийг үндэслэн ажлын 3-5 хоногийн дотор карт олгоно. Үүнд:
 - 2.1.1. Харилцагчаар бүртгүүлэх хүсэлт;
 - 2.1.2. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээ авах хүсэлт;
 - 2.1.3. Иргэний үнэмлэх эсвэл гадаад паспорт;
 - 2.1.4. ХШЕН-д заасны дагуу картан дансандаа заавал байлгах доод үлдэгдэлийг байршуулж, элсэлтийн хураамж болон жилийн хураамж төлсөн байх.
- 2.2. Цахим банк үйлчилгээ ашиглан карт захиалсан бол тухайн картыг хүлээн авахаар сонгосон Салбар, Тооцооны төвд ажлын 3-5 хоногийн дотор хүргэгдэнэ.

- 2.3. Шуудан үйлчилгээг ашиглан захиалсан картыг хүлээн авахаар хүсэлтийг банкинд өгсөн бол энэхүү гэрээний 2.1, 2.2-д заасан хугацаа хамаарахгүй болно.
- 2.4. КЭ картыг ашигласан эсэхээс үл хамааран картын дансыг ашиглах боломжтой бөгөөд карт ашиглахгүйгээр хийсэн гүйлгээг харилцах дансны гүйлгээтэй адилтган Банкны ХШЕН-д заасан нөхцөлийг баримтлана.

Гурав. Банкны эрх, үүрэг

- 3.1. Банк дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 3.1.1. КЭ-д картыг хэрхэн хэрэглэх талаар заавар, зөвлөмж өгөх;
 - 3.1.2. КЭ-ийн дансны үлдэгдэлд ХШЕН-д заасны дагуу хүү тооцож олгох;
 - 3.1.3. КЭ шинээр карт авах, дэд карт нээлгэх, картын хугацаа сунгуулах, алдаж үрэгдүүлсэн, гэмтсэн карт дахин авах талаар гаргасан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;
 - 3.1.4. КЭ-ийн картаараа хийсэн төлбөр, тооцоог картын данснаас тухай бүр гүйцэтгэж байх;
 - 3.1.5. КЭ-ийн хүсэлтээр дансны хуулга болон гүйлгээний талаарх мэдээллийг цаг тухайд нь гаргаж өгөх;
 - 3.1.6. КЭ-ийн картын данс болон бусад мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд чандлан хадгалах;
 - 3.1.7. Банк нь картаар гүйлгээ хийгдсэн эсэх мэдээллийг /цахим шуудангаар г.м/ үнэ төлбөргүй КЭ-д мэдэгдэх нэгээс доошгүй суваг үйлчилгээний нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх;
 - 3.1.8. КЭ төлбөр төлсөн бараа, үйлчилгээг буцаасан эсвэл илүү дүнгээр гүйлгээ хийсэн бол холбогдох дүнг уг ҮБ-ын бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн холбогдох журмын дагуу харилцагчийн картын данс руу буцаан олгох;
 - 3.1.9. Картын төлбөр, тооцоотой холбогдон КЭ болон банктай гэрээ байгуулсан ҮБ-ын хооронд үүссэн маргаантай асуудлыг КЭ, ҮБ хоёрын аль нэг талын хүсэлтээр 3 талын оролцоотойгоор хамтран шийдвэрлэх;
 - 3.1.10. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу КЭ-ч Банканд эзэмшиж буй картын дансанд орлого, түүнтэй адилтгах бусад орлогод оногдох албан татвар, суутгалыг хууль тогтоомжид нийцүүлэн суутгах, холбогдох татварын байгууллагад шилжүүлэх;
 - 3.1.11. Дотоодын болон Олон улсын Дебит картын хувьд Монгол улсын картын сүлжээнд гарсан картын гүйлгээний төлбөр тооцоотой холбоотой маргааныг Монголбанкны Төлбөрийн картын журам, “Улаанбаатар хотын банкны картын маргаантай гүйлгээг шалгах, шийдвэрлэх журам” болон бусад хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх;
 - 3.1.12. Олон улсын Дебит картын хувьд Виза интернэйшнл байгууллагын сүлжээнд олон улсын банк, санхүү, үйлчилгээний газар хийсэн КЭ-ийн картын гүйлгээнд Маргаан үүссэн бол Виза интернэйшнл байгууллагын холбогдох журмын дагуу шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд банк КЭ-ийг хохиролыг барагдуулах үүрэг хүлээхгүй болно;
 - 3.1.13. Картаар хийгдсэн маргаантай буюу тодруулах шаардлагатай гүйлгээний талаар КЭ банкинд хүсэлт гаргасан бол Банк АТМ, ПОБ -ын гүйлгээний хүсэлтийн хариуг Карт хүлээн авагч банкинд бүртгүүлснээс хойш ажлын 3 хоногийн дотор, ПОС-ын гүйлгээний хүсэлтийн хариуг ажлын 10 хоногийн дотор, Олон улсын картын сүлжээний АТМ, ПОБ, ПОС-ын гүйлгээний хүсэлтийн хариуг хуанлийн 30-45 хоногийн дотор КЭ-д мэдэгдэх;
 - 3.1.14. Энэхүү гэрээний 3.1.13-д заасны дагуу хүсэлтийн хариуг КЭ хүлээн зөвшөөрөхгүй бол гэрээний 3.1.11, 3.1.12-д заасан журам зааврын дагуу шийдвэрлэнэ.
- 3.2. Банк дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 3.2.1. Картын үйлчилгээний хүү, шимтгэл, хураамжыг ХШЕН-д заасны дагуу КЭ-ийн картын данснаас үл маргах журмаар суутган авах;
 - 3.2.2. КЭ-ийн картаараа хийсэн төлбөр, тооцоог Монгол улсын картын сүлжээнд хийгдсэн гүйлгээний хувьд тухай бүр, Олон улсын картын сүлжээнд хийгдсэн бол гүйлгээ хийгдснээс хойш 30 хоногийн дотор холбогдох данснаас нь суутган авч байх;
 - 3.2.3. Монгол улсад байрлах АТМ-д хураагдсан картыг тухайн өдрөөс хойш 3 сарын хугацаанд банкнаас аваагүй бол картыг хүчингүй болгох;
 - 3.2.4. Сүүлийн 2 жилийн хугацаанд картын дансаараа гүйлгээ хийгээгүй, дансны үлдэгдэл нь заавал байлгах үлдэгдлийн доод хэмжээг хангаагүй тохиолдолд карт болон картын дансыг хаах;
 - 3.2.5. КЭ-ийн картаар сэжигтэй, луйврын шинжтэй байх магадлалтай гүйлгээ гарсан тохиолдолд КЭ-ийн банканд бүртгүүлсэн утас, и-мэйл хаягаар холбогдож гүйлгээг баталгаажуулах, холбогдох боломжгүй тохиолдолд картыг түр хугацаанд хаах;
 - 3.2.6. КЭ-ийн буруугаас Банк, ҮБ болон бусад хохирол учирсан нь тогтоогдсон бол КЭ-ийн картын болон бусад данснаас үл маргах журамаар суутган авах, дансан дахь үлдэгдэл нь хохирлыг бүрэн барагдуулж хүрэхгүй тохиолдолд хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах;
 - 3.2.7. КЭ –ийн буруугаас Банк, ҮБ болон бусад хохирол учирсан нь тогтоогдсон бол КЭ-ийн картын болон бусад данснаас үл маргах журмаар суутган авах, дансан дахь үлдэгдэл нь хохирлыг бүрэн барагдуулж хүрэхгүй тохиолдолд хуульд заасны дагуу бусад арга хэмжээг авах;
 - 3.2.8. КЭ захиалсан картаа Шуудангийн үйлчилгээгээр хүлээн авахаар ХШЕН-д заасан хураамжийг төлсөн боловч шууданг хүлээн авах хаягтаа байгаагүй, эсвэл хаягаа алдаатай бүртгүүлсэнээс болж картаа хүлээн авч чадаагүй бол шимтгэлийг банк буцаан олгохгүй байх;
 - 3.2.9. Зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч Банкны дотоод шийдвэрээр ХШЕН-д өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд нийтэд зарласан өдрөөс эхлэн мөрдөх;
 - 3.2.10. Зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч Банкны дотоод шийдвэрээр гэрээнд өөрчлөлт оруулах;
 - 3.2.11. Банк гэрээнд өөрчлөлт оруулах талаар карт эзэмшигчдэд хуанлийн 30/гуч/ хоногийн өмнө банкны холбогдох суваг/вэбсайт, интернэт банк/-р мэдээлснээр гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд карт эзэмшигч заасан хугацаанд гэрээнээс татгалзаагүй бол, гэрээний өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
 - 3.2.12. КЭ нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, гүйлгээ хийх эрхийг зогсоох;

Дөрөв. Карт эзэмшигчийн эрх, үүрэг

- 4.1. КЭ дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 4.1.1. Дансанд заавал байлгах үлдэгдлийг тогтмол байршуулах;
 - 4.1.2. Банкны www.ubcbank.mn цахим хаягаар дамжуулан ХШЕН-тэй танилцаж байх;
 - 4.1.3. ХШЕН-д заасан хураамж, шимтгэлийг төлөх үүрэгтэй бөгөөд картын данснаас хураамж, шимтгэлийг суутгах эрхийг Банканд үүгээр олгох;
 - 4.1.4. Дансыг хамтран эзэмших эрх бүхий дэд КЭ-ийн картаар хийсэн төлбөр, тооцоог болон түүнтэй холбогдон үүсэх маргаан, эрсдэлийг бүрэн хариуцах;
 - 4.1.5. КЭ-ийн талаарх мэдээлэл өөрчлөгдөх бүрд Банканд мэдэгдэж шинэчлүүлж байх, мэдэгдээгүйн улмаас үүсэх аливаа хохирлыг бүрэн хариуцах;
 - 4.1.6. Картын нууцлал болох картын дугаар, хүчинтэй хугацаа, CVV код, картын ПИН код, интернет ПИН код, Картын соронзон туузанд бичигдсэн мэдээллийн нууцлалыг нарийн чанд хадгалах, бусдад мэдэгдэхгүй буюу мэдэгдэх нөхцлөөр хангахгүй байх, картаа бусдад ашиглуулахгүй байх үүрэгтэй бөгөөд картын нууцлалаа алдсанаас үүсэх аливаа эрсдэл, хохирол зардлыг бүрэн хариуцах;
 - 4.1.7. Дансны гүйлгээний хуулгыг Цахим банк үйлчилгээгээр тогтмол шалгаж, маргаантай буюу хүлээн зөвшөөрөхгүй ямар нэгэн гүйлгээ хийгдсэн тохиолдолд тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш гэрээний 4.2.7-д заасан хугацааны дотор банканд мэдэгдэж шалгуулах, мэдэгдээгүй эсвэл заасан хугацаанаас хойш мэдээллийн улмаас үүссэн хохирлыг КЭ өөрөө бүрэн хариуцах;
 - 4.1.8. Картын гүйлгээтэй холбоотой үүсгэсэн маргааныг шалгах явцад КЭ нь Гэрээгээр хүлээсэн үүрэг болон төлбөрийн карт хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн болох нь нотлогдсон тохиолдолд гарсан зардлыг бүрэн хариуцах;
 - 4.1.9. Өөрийн карт буюу пин кодыг хаяж үрэгдүүлсэн, хулгайд алдсан, өөрийн данснаас эрх олгогдоогүй шилжүүлэг хийгдсэн болон бүртгэлийн аливаа алдаа, зөрчил дутагдлыг илрүүлсэн, картын пин код, картын мэдээллийг гуравдагч этгээд мэдсэн байж болзошгүй гэж үзсэн тохиолдолд Банкны Харилцагчийн мэдээллийн төвийн /1800-1800/ дугаарын утсанд мэдэгдэж хаалгах эсвэл Цахим банкны үйлчилгээгээр нэн даруй картаа өөрөө хаах бөгөөд эдгээр үйлдлийг хийгээгүйн улмаас үүсэх хохирлыг өөрөө бүрэн хариуцах;
 - 4.1.10. КЭ картаа банкинд мэдэгдэж хаалгасан бол хаалгахаас өмнө тус картаар хийсэн аливаа гүйлгээний нэхэмжлэл, авлагын төлбөр тооцоог карт эзэмшигч бүрэн хариуцна;
 - 4.1.11. Банкны харилцагчийн мэдээллийн төвөөр буюу зайнаас үйлчилгээ авсантай холбоотой үүссэн аливаа маргаан, хохирол, зардлыг КЭ өөрөө бүрэн хариуцах;
 - 4.1.12. Цахим банк үйлчилгээ ашиглан хийсэн карттай холбоотой аливаа гүйлгээ, үйлдлийн үр дагаврыг бүрэн хариуцах;
 - 4.1.13. Шуудангийн үйлчилгээг ашиглан захиалсан картаа хүлээн авахдаа дугуйны битүүмжийг сайтар шалган авах ёстой бөгөөд битүүмж задарсан бол картыг хүлээн авахгүй байж банкинд энэ талаар нэн даруй мэдэгдэх;
 - 4.1.14. Шуудан үйлчилгээг зөвхөн Монгол Улсын нутаг дэвсгэрийн хүрээнд ашиглах;
 - 4.1.15. Шуудан үйлчилгээг ашиглан захиалсан картаа хүлээн авсан бол өөрийн бүртгэлтэй Цахим банк үйлчилгээгээр картыг идэвхжүүлэх;
 - 4.1.16. Захиалсан картаа Шуудан үйлчилгээгээр хүлээн авахаар ХШЕН-д заасан хураамжийг төлсөн боловч шууданг хүлээн авах хаягтаа байгаагүй, эсвэл хаягаа буруу бүртгүүлсэн гэх зэргээс шалтгаалж картаа хүлээн авч чадаагүй бол карт захиалсан салбар, тооцооны төвөөс биеэр очиж хэвлэгдсэн картыг авах бөгөөд төлсөн шимтгэлийг буцаан олгогдохгүй.
 - 4.1.17. Дотоодын болон олон улсын Дебит картын хувьд Монгол улсын төлбөрийн сүлжээнд КЭ-ийн хийсэн картын гүйлгээнд Маргаан үүссэн бол Банкны журам, заавар, Монолбанкны журам, зааврын дагуу шийдвэрлүүлэх бөгөөд КЭ-ийн эсрэг шийдвэрлэгдсэн бол хохирол, үр дагаварыг бүрэн хариуцах;
 - 4.1.18. Олон улсын Дебит картын хувьд Виза интернэйшнл байгууллагын сүлжээнд олон улсын банк, санхүү, үйлчилгээний газар хийсэн КЭ-ийн картын гүйлгээнд Маргаан үүссэн бол Виза интернэйшнл байгууллагын холбогдох журмын дагуу шийдвэрлүүлэх бөгөөд КЭ-ийн эсрэг шийдвэрлэгдсэн бол хохирол, үр дагаварыг бүрэн хариуцах;
 - 4.1.19. Картын гүйлгээтэй холбоотой үүсгэсэн маргааныг шалгах явцад КЭ нь Гэрээгээр хүлээсэн үүрэг болон төлбөрийн карт хэрэглэх заавар, зөвлөмжийг зөрчсөн болох нь нотлогдсон тохиолдолд гарсан зардлыг бүрэн хариуцах;
 - 4.1.20. Виза интернэйшнл байгууллага, Монголбанк болон төлбөрийн системд оролцогч бусад байгууллагуудын сүлжээнд КЭ-ийн хийсэн гүйлгээ, тухайн гүйлгээний валютын төрөл, ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан үүсч болох ханшийн зөрүү, Виза интернэйшнл байгууллага, Монголбанк болон төлбөрийн системд оролцогч бусад байгууллагуудын зүгээс ХШЕН-өөс гадна нэмж тооцох үйлчилгээний нэмэгдэл төлбөр, хураамж, шимтгэлийг карт эзэмшигч бүрэн хариуцах;
 - 4.1.21. Олон улсын төгрөгийн данстай Дебит картын хувьд Виза интернэйшнл байгууллагын сүлжээнд хийсэн бүх гүйлгээ нь Банкны бэлэн бус ам.доллар зарах ханшаар хөрвөх бөгөөд картын гүйлгээний валют нь төгрөг, ам.доллараас өөр валют бол ам.доллар тухайн гуравдагч валюттай харьцах ханш нь Виза интернэйшнл байгууллагын ханш байх тул тус ханшын зөрүүг харилцагч бүрэн хариуцах үүрэгтэй;
- 4.2. КЭ дараах эрх эдэлнэ. Үүнд:
- 4.2.1. Банкнаас өөрийн дансны үлдэгдэл болон гүйлгээний талаар хуулга, мэдээ, тайлбар авах;
 - 4.2.2. Банканд бичгээр хүсэлт гаргаж, данс хамтран эзэмших эрхтэй дэд картыг бусдад олгуулах;
 - 4.2.3. Эзэмшиж буй картаараа дамжуулан Банкнаас үзүүлж буй нэмэлт үйлчилгээг авах;
 - 4.2.4. Картын хүчинтэй хугацаа нь дууссан, гэмтсэн, алдаж үрэгдүүлсэн бол карт нөхөж авах, Пин кодоо мартсан бол шинээр авах хүсэлтийг Банканд гаргаж, шийдвэрлүүлэх;
 - 4.2.5. Өөрийн хүсэлтээр хугацаанаас нь өмнө Гэрээг цуцлах;
 - 4.2.6. Картаар нэг өдөрт хийх гүйлгээний лимитийг өөрчлүүлэх;
 - 4.2.7. Монгол улсын картын сүлжээнд картаар хийгдсэн маргаантай буюу тодруулах шаардлагатай гүйлгээний талаар АТМ, ПОБ -ын гүйлгээ бол гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш ажлын 40 хоногийн дотор, ПОС-ын гүйлгээ бол ажлын 60 хоногийн дотор, Олон улсын картын сүлжээний АТМ, ПОБ-ын гүйлгээ бол хуанлийн 75 хоног, ПОС-ын гүйлгээ бол хуанлийн 120 хоногийн дотор Банканд биеэр ирж бичгээр эсвэл Банкны Харилцагчийн мэдээллийн төвийн лавлах дугаар 18001800 хандаж хүсэлт гаргах;

4.2.8. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Банкнаас шаардах.

Тав. Картаар хийх гүйлгээ болон ашиглалтад хязгаарлалт тавих

- 5.1. Карт ашиглалт, гүйлгээний аюулгүй байдлыг хангах үүднээс Банк дараах нөхцөл, хязгаарлалтуудыг тогтооно. Үүнд:
 - 5.1.1. Банкны салбар, тооцооны төвөөс нэг өдөрт авах бэлэн мөнгөний дээд хэмжээ, гүйлгээний тоо;
 - 5.1.2. Үйлчилгээний байгууллагаар өдөрт үйлчлүүлэх гүйлгээний тоо, дээд хэмжээ;
 - 5.1.3. Нэг өдөрт АТМ-аас бэлэн мөнгө авах гүйлгээний тоо, дээд хэмжээ;
 - 5.1.4. Картын пин код АТМ-д алдаатай оруулах тоо;
 - 5.1.5. АТМ-д ямар нэгэн үйлдэл хийгээгүйгээс картыг хураан авах хугацаа;

Зургаа. Маргаан шийдвэрлэх

- 6.1. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг Талууд эвийн журмаар шийдвэрлэнэ.
- 6.2. Картаар хийгдсэн маргаантай эсвэл хүлээн зөвшөөрөхгүй байгаа аливаа гүйлгээг дотоодын банкны сүлжээнд гарсан маргаан бол Улаанбаатар хотын банкны болон Монголбанкны гаргасан журам заавраар, олон улсын сүлжээнд гарсан маргаан бол Виза интернэйшнл байгууллагын журам, зааврын дагуу шийдвэрлэнэ.
- 6.3. Олон улсын сүлжээнд хийсэн гүйлгээний маргааны хувьд Виза интернэйшнл байгууллагын журам, зааврын дагуу шийдвэрлэсэн арбитрын шийдвэр нь эцсийн шийдвэр байна.
- 6.4. Талуудын хооронд үүссэн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй, буруутай тал нь тогтоогдоогүй байхад, Банкны нэр хүндэд халдах, гутаах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сөрөг мэдээ тараахыг хориглоно. Үүний улмаас Банкинд учирсан хохирлыг бүрэн хариуцаж барагдуулна.
- 6.5. Талуудын хооронд үүсэх маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ. Энэ заалт гэрээний 6.3-т заасан маргаанд хамаарахгүй.

Долоо. Хариуцлага

- 7.1. КЭ өөрийн карт (ууд)-ын болоод дэд карт (ууд)-аар хийсэн /хийгдсэн, хийх/ төлбөр тооцоо, үйлчилгээний хураамж, шимтгэлийг банк болон үйлчилгээний байгууллага, бусад төлбөрийн системд оролцогч байгууллага дотоодын болон гадаад улсын байгууллага, банкуудын өмнө бүрэн хүлээж хариуцна.
- 7.2. КЭ өөрийн картын найдвартай байнгын ажиллагааны дагуу картын ар талд баталгаат гарын үсгийг зурах, пин код, хүчинтэй хугацааны дуусах хугацааг анхаарч үйлчлүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд банкинд тухай бүр нь мэдэгдэж картаа шалгуулах, картын хугацааг сунгуулах, дахин хэвлүүлэх, пин кодыг шинээр авах үүрэгтэй ба шалгаагүй, банкинд мэдэгдээгүйгээс болж өөрт учирсан аливаа хохирол, маргаантай асуудлыг харилцагч өөрөө хариуцах ба банк хариуцахгүй.
- 7.3. КЭ гэрээний 4.1.9-д заасны дагуу карт хаалгасан бөгөөд буцаан нээгээгүй бол хаалгаснаас хойш тухайн картаар хуурамч болон залилан мэхлэх шинжтэй гүйлгээ хийх зөвшөөрөл өгснөөс үүсэх хохирлыг Банк хариуцна.
- 7.4. Олон улсад ашиглагдах Дебит картын хувьд Виза интернэйшнл байгууллагын сүлжээнд олон улсын банк, санхүү, үйлчилгээний газар хийсэн КЭ-ийн маргаантай гүйлгээтэй холбоотой асуудлыг Банк харилцагчийн хүсэлтийг үндэслэн түүнийг төлөөлөн холбогдох журмын дагуу харилцаж болох боловч энэ нь Банк харилцагчийн хохирлыг барагдуулах үндэслэл болохгүй буюу КЭ хохирлыг бүрэн хариуцна.
- 7.5. Дотоодод эсвэл олон улсад ашиглагдах Дебит картын хувьд дотоодын банкны сүлжээнд гаргасан Төлбөрийн картын маргаантай холбоотой асуудлыг харилцагчийн хүсэлтийг үндэслэн түүнийг төлөөлөн холбогдох банкуудтай харилцаж болох боловч энэ нь Банк харилцагчийн хохирлыг барагдуулах үндэслэл болохгүй буюу КЭ хохирол, үр дагаварыг бүрэн хариуцна.
- 7.6. КЭ өөрийн захиалсан картыг өөр хүнд хүлээлгэн өгөх хүсэлт гаргасан, эсхүл дансаар цалин олгох гэрээт байгууллагын ажилтны картыг тухайн байгууллагаас томилогдсон ажилтанд шилжүүлсэн бол тус хэвлэгдсэн картыг өөр хүнд хүлээлгэн өгсөнтэй холбогдон гарах, гарч болзошгүй аливаа эрсдэл, хохирол, зардлыг КЭ бүрэн хариуцах бөгөөд банк картыг өөр хүнд хүлээлгэн өгсөнтэй холбоотой ямарваа нэгэн үүрэг, хариуцлага хүлээхгүй.
- 7.7. КЭ өөрийн гэрийн хаяг, гар утас, гэрийн утас, и-мэйл хаяг зэрэг карт эзэмших хүсэлтэд бөглөж өгсөн мэдээллүүд өөрчлөгдсөн даруйд Банкинд мэдэгдэж байх үүрэгтэй бөгөөд энэхүү үүргээ биелүүлээгүйгээс болж үүссэн хохирлыг банк хариуцахгүй.

Найм. Гэрээний хугацаа, гэрээ дуусгавар болох

- 8.1. Гэрээний хугацаа нь картын хугацаатай ижил байх ба карт хүчинтэй байх хугацаанд Гэрээний бүх заалтууд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 8.2. Гэрээний нөхцөл бүрэн биелэгдэж Гэрээ цаашид сунгагдахгүй болсноор буюу Гэрээг аль нэг талын санаачлагаар хугацаанаас өмнө цуцалснаар дуусгавар болно.
- 8.3. Хэрвээ Карт эзэмшигч нь картын данстай холбогдох аливаа өр, төлбөрийг бүрэн барагдуулаагүй бол тухайн төлбөрийг хүүгийн хамт бүрэн барагдуулж дуустал картын дансанд хаалт тавьж, барагдуулж дууссан өдрөөс Гэрээг цуцалж, гэрээний хугацааг дуусгавар болсонд тооцно.

Ес. Бусад зүйл

- 9.1. Гэрээ нь Талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2. Энэ гэрээний дагуу эзэмшиж буй картаар хийсэн гүйлгээний хувьд өөрийн картын мэдээллийг цахим гүйлгээний талбарт оруулсан; картыг ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжид уншуулсан; мөн гүйлгээг хийхэд Картын ПИН код, эсхүл Интернет ПИН код шаардсан бол тэдгээр кодыг оруулсан зэргийг холбогдох гүйлгээний баримтад зурсан гарын үсэг зурсантай адилтгаж тооцно.
- 9.3. Гэрээг хоёр хувь үйлдэж, хоёр тал тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.

9.4. Энэ гэрээг байгуулах өдрийн байдлаар мөрдөгдөж буй Картын үйлчилгээний ХШЕН-ийг гэрээний хавсралтад тусгасан бөгөөд уг нөхцөлийг Банк энэ гэрээнд заасан журмаар өөрчилж болно. КЭ нь энэхүү нөхцөлийг гэрээний Хавсралт №1-д дурдсан ХШЕН-тэй танилцаж зөвшөөрсний үндсэн дээр гэрээ байгуулсан болно.

Гэрээ байгуулсан:

Гэрээний нөхцлийг бүрэн уншиж танилцсан бөгөөд гэрээний нөхцөл болон картын үйлчилгээний хүү, шимтгэлийг хүлээн зөвшөөрч баталгаат гарын үсгээ зурав.

Банкийг төлөөлж:

Харилцагч:

/Баталгаат гарын үсэг/

/Баталгаат гарын үсэг/

/Овог, нэр/

/Овог, нэр/

ДЕБИТ КАРТЫН ХҮҮ, ШИМТГЭЛИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

Нөхцөл		Бүтээгдэхүүний нэр	
		
Дебит картын дансны валют			
Элсэлтийн хураамж /Карт анх нээх үед нэг удаа суутган авна/			
Жилийн хураамж /Картын хүчинтэй хугацаанд жил бүр суутган авна/			
Карт нөхөн авах /алдсан, гээсэн, гэмтээсэн/			
6 цагийн дотор карт хэвлүүлэх үйлчилгээний хураамж			
Картын ПИН код солих	УБХБ болон ХХБ-ны АТМ		
	Гэрээт банкуудын АТМ		
	УБХБ-ны салбар		
Дансны доод үлдэгдэл			
Дансны үлдэгдэлд тооцох жилийн хүү			
Өдрийн гүйлгэний хязгаар	АТМ болон Банкны салбараас картаар бэлэн мөнгө авах	Тоо	
		Дүн	
	Худалдан авалт хийх	Тоо	
		Дүн	
Картын ПИН код буруу хийх боломж	Тоо		
АТМ-р үлдэгдэл шалгах	Олон улсын АТМ-ээр		
	УБХБ болон ХХБ-ны АТМ-ээр		
	Гэрээт банкны АТМ-ээр		
	Бусад банкны АТМ		
АТМ –ээс бэлэн мөнгө авах	Олон улсын АТМ-ээс		
	УБХБ болон ХХБ-ны АТМ-ээс		
	Гэрээт банкны АТМ-ээс		
	Бусад банкны АТМ-ээс		
Банкны Салбар, Тооцооны төвөөс бэлэн мөнгө авах	Гадаадын банкны салбараас		
	УБХБ-ны салбараас		
	ХХБ-ны салбараас		
	Гэрээт банкны салбараас		
	Бусад банкны АТМ-ээс		

